

## Тээврийн хэлтэс

1956-7-23-нд Сайд нарын Зөвлөлийн 355-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяанд **аж ахуйн тооцоон дээр ажиллах авто баазыг** байгуулжээ.

1960-2-12-нд т Сайд нарын Зөвлөлийн 54-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяанд байгаа **олон жижиг баазуудыг** 1960-3-1-нээс нэгтгэж.

- - Хотын худалдаа, нийтийн хоолны трестүүдийн авто бааз
- - **Хотын нийгэм хангамжийн үйлчилгээний авто бааз болгон** байгуулжээ.
- Богинын тээврийн авто баазыг 1960-2-15-наас Улаанбаатар хотын захиргааны харьяанд байгуулахаар тогтоожээ.

1961-6-21-нд Сайд нарын Зөвлөлийн 327-р тогтоолоор Улаанбаатархотод 300 морин тэрэгтэй, **морин тээврийн баазыг** 1961-8-1-нээс байгуулахыг Улаанбаатар хотын захиргаанд зөвшөөрчээ. 1961-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс, хөдөлмөрийн товчоо, тээврийн хэлтсийг татан буулгасан

1964-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор **Нийгэм хангамжийн газрыг** өргөтгөж, богины тээврийн баазыг нийгэм хангамжийн авто баазад нэгтгэх.

1963-7-1-нд сайд нарын Зөвлөлийн 318-дугаар тогтоолоор **Улсын барилга эдийн засгийн комиссын ерөнхий захилагчийн газар татан буугдаж** байгаатай холбогдуулан “Алтай” зочид буудал мэргэжилтний орон сууцны захиргаа, үйлчилгээний **авто баазуудыг** нэгтгэж **аж ахуйн тооцоотой мэргэжилтнийг үйлчлэх газрыг** байгуулахаар тогтоожээ. 1977-8-6-нд Сайд нарын Зөвлөлийн 245- дугаар тогтоолоор Улаанбаатар хотод байгаа **материал-техникийн хангамжийн ерөнхий газар, конторын машин, механизмыг нэгтгэн төвлөрүүлж материал-техникийн хангамжийн хороонд** харьяалуулжээ.

1978-7-22-нд сайд нарын Зөвлөлийн 212-р тогтоолоор Улаанбаатарын угсармал барилга-үйлдвэрлэлийн нэгдлийг байшин үйлдвэрлэх комбинат, угсармал барилгын трест, авто тээвэр, барилгын машин механизмын бааз, технологийн иж бүрдэлтийн контортойгоор 1978-8-1-нээс байгуулж, Барилга барилгын материалын үйлдвэрийн яаманд харьяалуулахаар тогтоожээ.